



20²⁴ оны ⁰⁹ дугаар
сарын ¹⁶ -ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН А Л Б А Н Д А А Л Г А В А Р

Дугаар 01

Улаанбаатар хот

Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын
зарим арга хэмжээний хэрэгжилтийг
эрчимжүүлэх тухай

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, цар тахлын дараахь санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг богино хугацаанд сайжруулах шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор дараахь чиглэлээр асуудлыг нарийвчлан судалж 30 хоногийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус ДААЛГАСУГАЙ:

1.Дор дурдсан төсөл, арга хэмжээний талаар шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд:

1.1.Оросын Холбооны Улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу тавих байгалийн хийн хоолой барих төслийн бэлтгэл ажлын явц байдал;

1.2.Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур чөлөөт бүсийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, зохицуулалт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж танилцуулах;

1.3.Хөшигийн хөндийд чөлөөт бүс байгуулах тооцоо, судалгааг яаралтай боловсруулж танилцуулах;

1.4.Төрийн худалдан авах ажиллагааг бүрэн цахимжуулах.

2.Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид:

2.1.Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг эрчимжүүлж, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрыг чадавхжуулах арга хэмжээ авах;

2.2.“Иргэд, олон нийттэй харилцах-1111” төвийн үйл ажиллагааг мэдээллийн технологийн шинэ дэвшилтэт шийдэл, техник хэрэгсэлд тулгуурлан боловсронгуй болгон сайжруулах санал боловсруулан танилцуулах;

2.3.Шинээр боловсруулж буй хууль, эрх зүйн зохицуулалттай уялдуулан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгон шинэчлэх санал боловсруулан танилцуулах;

0021900004

2.4.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан хэлэлцүүлэх;

2.5.Аймаг, нийслэлийн Засаг даргын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хог хаягдал, байгаль орчны асуудлыг шалгуур үзүүлэлт болгон оруулах арга хэмжээ авч, дүнг танилцуулах;

2.6.“Цар тахлын үеийн эдийн засгийг эрчимжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндэсний хороо”, “Цахим засаглалд шилжиж, хүнд суртал, авлигагүй, төрийн үйлчилгээг бүрдүүлэх үндэсний хороо”, “Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо”, “Иргэдийн орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх, хуримтлалын нэгдсэн сан, Үндэсний баялгийн санг бүрдүүлэх, дундаж давхаргыг тэлэх үндэсний хороо”, “Олимпизмыг дэлгэрүүлэх, хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтийг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх үндэсний хороо”-ны Ажлын алба байгуулах талаар санал боловсруулан танилцуулах.

3.Эдийн засаг, хөгжлийн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар санал бэлтгэн танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Сангийн сайд Б.Жавхлан нарт.

4.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт:

4.1.Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Бүгд Найрамдах Сингапур Улсад хийх Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын үеэр танилцуулах тэргүүлэх ач холбогдол бүхий тус бүр 10 төсөл, арга хэмжээг сонгож, айлчлалын бэлтгэл ажлын явцыг танилцуулах;

4.2.Засгийн газрын цахим хуудсыг шинэчлэх.

5.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд:

5.1.Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын холболтын цэгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохирох арга хэмжээ авч, үр дүнг танилцуулж шийдвэрлүүлэх;

5.2.Уул уурхайн бирж байгуулах тооцоо, судалгааг боловсруулж танилцуулах;

5.3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг “Төрийн өмчийн корпораци” болгон өөрчлөн зохион байгуулах саналыг холбогдох хууль тогтоомжийн төслийн хамт боловсруулан хэлэлцүүлэх.

6.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт:

6.1.авто замын гэрлэн дохиог нэгдсэн хяналтын сүлжээнд холбон автоматжуулах, хиймэл оюун ухаанд суурилсан технологи нэвтрүүлэх техник, технологийн шийдлийг боловсруулж танилцуулах;

6.2.хорих ялын бодлогыг хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулан танилцуулах;

6.3.Оюутолгой төслийн яриа хэлэлцээ хийх ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулагч талтай үр ашигтай тохиролцоо хийсний үндсэн дээр төслийн далд уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх арга хэмжээ авч, дүнг танилцуулах;

6.4.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх;

6.5.Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх;

6.6.Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх.

7.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад:

7.1.Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх;

7.2.Хуримтлалын нэгдсэн сан байгуулах талаар тодорхой санал боловсруулан танилцуулах;

7.3.Залуусыг ажил хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөл болон халамжаас хөдөлмөрт шилжих бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх.

8.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт:

8.1.Хөшигийн хөндийд суурьшлын шинэ бүс бий болгох ТЭЗҮ, тооцоо, судалгаа, төлөвлөлт, түүнд үндэслэсэн санхүүжилтийн шаардагдах эх үүсвэрийг тооцож Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгуулах саналаа танилцуулах;

8.2.Иргэн, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх, өмчлүүлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, газар эзэмшигч, өмчлөгчийн мэдээллийг нийтэд ил тод болгох асуудлыг судлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.

9.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд:

9.1.Их, дээд сургуулиудыг нэгтгэн зохион байгуулж, Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймагт МУИС-ийн төрөлжсөн салбар сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” хэлбэрээр байгуулан хөгжүүлэх асуудлыг судлан танилцуулах;

9.2.Англи хэлийг албан ёсны 2 дахь хэл болгох асуудлыг судлан танилцуулах;

9.3.Монгол үндэсний бичгээр төрийн албан хэргийг хөтлөх асуудлыг судлан танилцуулах.

10.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт:

10.1.Богдхан төмөр зам төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, төмөр замын чиг, трассыг батлуулах, санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг судлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

10.2.Улаанбаатар-Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замын барилгын ажлыг чанартай барьж дуусгах, ашиглалтад бүрэн өгөх хугацааг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан тооцож тодорхойлох;

10.3.Хилийн боомтуудыг холбох авто зам, аялал жуулчлалын шинэ авто зам барих дунд, урт хугацааны төлөвлөлт, тооцоо, судалгааг боловсруулж танилцуулах.

11.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг судлан тодорхой санал бэлтгэн танилцуулахыг Соёлын сайд Ч.Номинд.

12.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд:

12.1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх;

12.2.Эрдэс баялгийн бирж байгуулах асуудлыг судлан танилцуулах;

12.3.Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн бүтээн байгуулалтад байнгын хяналт тавьж, газрын түүхий тос дамжуулах хоолойн барилга угсралтын ажлыг шуурхай эхлүүлэх;

12.4.Зэс хайлуулах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх;

12.5.“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг түшиглэн нүүрс угаах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх;

12.6.Хар төмөрлөгийн (кокс, ширэм, шууд ангижруулсан төмөр) үйлдвэрлэлийг Дархан-Уул, Орхон, Дорноговь аймагт хөгжүүлэх асуудлыг судлан ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

12.7.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх;

12.8.Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж, хүнээс хамааралгүй, ил тод, шуурхай болгох;

12.9.Катодын зэс үйлдвэрлэдэг “Ачит Ихт” ХХК-ийн 34 хувийг төрд үнэ төлбөргүй шилжүүлэн авах ногдол ашгийг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомж, гэрээний хүрээнд шийдвэрлэж, дүнг танилцуулах.

13.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд:

13.1.Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах тооцоо, судалгаа, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг судлан танилцуулах;

13.2.Улаанбаатар хот болон томоохон суурин газарт хүнсний баталгаат агуулах барих асуудлыг судлан танилцуулах.

14.Дараахь төсөл, арга хэмжээний шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэхийг Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд:

14.1.Тавантолгойн дулааны цахилгаан станц барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл;

14.2.Улаанбаатар хотод эрчим хүчний 5 дахь эх үүсвэр бий болгох асуудлыг судлан тодорхой санал боловсруулах;

14.3.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг шуурхай эхлүүлэх.

15.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод:

15.1.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтыг эрчимжүүлэх зайлшгүй шаардлагыг харгалзан 2021 онд багтаан зорилтот бүлгийн иргэдийг 3 дахь буюу бүүстэр тунд бүрэн хамруулах боломжийг судлан саналаа танилцуулах;

15.2.Иргэн бүр эрүүл мэндийн бүрэн шинжилгээ-оношилгоонд жилд 1 удаа хамрагддаг байх тогтолцоог бүрдүүлэх тооцоо, судалгаа, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгуулах саналаа танилцуулах;

15.3.Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв, Зүрх судасны үндэсний төв, Түлэнхийн төв, Хавдар судлалын үндэсний төвийн барилгыг шинээр барих зураг төслийг боловсруулж, санхүүжилтийн шаардагдах эх үүсвэрийг тооцож Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгуулах саналаа танилцуулах.

16.Хог, хаягдал боловсруулах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, үр ашгийн тооцоо, судалгаа, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг судлан тодорхой хувилбар, шийдэл танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт даалгасгай.

17.Албан даалгаварт тусгагдсан төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд онцгой анхаарч ажиллахыг Засгийн газрын нийт гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

18.Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд ажлын явц байдалтай газар дээр нь танилцаж салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд



Л.ОЮУН-ЭРДЭНЭ